

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ОРОН ТООНЫ БУС ДЭД ЗӨВЛӨЛИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.12.20

№	Гүйцэтгэх ажил, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа /улирал/				Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлт	Санхүү жилтий н эх үүсвэр	Хүрэх үр дүн	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт (%)
		I	II	III	IV						
Нэг . Эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд											
1.1	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах. (ЗГҮАХХАХТ-2.5.8)</p> <p>Тус яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт</p>					Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөхтэй холбоотой норм, дүрэм, стандартад үзлэг хийх ажлыг зохион байгуулна.	Үзлэг-1, Дүгнэлт-1	-	“Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийн түвшин тогтоох үзлэг” хийх ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын салбарт хамаарах хүртээмжтэй холбоотой хууль тогтоомжууд, тэдгээрт тусгагдсан заалтуудын жагсаалт судалгааг гарган, санал боловсруулсан байна.	БХБЯ, БХТ ТӨААТҮГ	<p>- Тус ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын салбарт хамаарах хүртээмжтэй холбоотой хууль тогтоомжууд, тэдгээрт тусгагдсан заалтуудын жагсаалт судалгааг гарган, шаардлагатай норм нормативын баримт бичгийг боловсруулахаар санал, дүгнэлт гарсан. Үүнээс Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд 6 БНБД, 7 БД, 25 стандарт тусгагдсан.</p> <p>- Мөн Барилгын тухай хуулийг шинэчлэн боловсруулж байгаатай холбоотой БНСУ-ын барилгын ерөнхий хуулийг эх материалын болгон судалгааны ажлыг хийж баримт бичгийн эмхэтгэлийг монгол хэлнээ хөрвүүлсэн.</p> <p>- Улмаар Барилгын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийг дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулсан. Өнөөдрийн байдлаар дээрх төслүүдийг боловсруулах ажлын хүрээнд 54 удаагийн уулзалт хийж холбогдох</p>

									саналуудыг авч тусган ажилласан. Ингээд Зөвлөх үйлчилгээний багаас 2024 оны 3 дугаар улиралд ирүүлсэн төслийг хянаж, нягтлан боловсруулж эцэслэсэн. - "Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг шинэчлэн боловсруулсан бөгөөд 2025 онд ЗГ-ын хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Биелэлт 100%	
1.2	Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын даалгаварт ХБИ-д зориулсан тусгай шаардлага, холбогдох норм, дүрэм, стандартуудыг тусгаж, хэрэгжүүлэх, хяналт тавин ажиллах. (Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дэх заалт, 15 дугаар заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл)				- "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 35-01-22/ барилгын норм, дүрмийн дагуу зураг төсөл боловсруулах, магадлалын дүгнэлтээр баталгаажуулах, - БХТ-ийн Магадлалын хэлтэс тайлангаа БХБЯ-д хагас бүтэн жилээр ирүүлэх, тайлагнах.	- Магадлалын дүгнэлтээр баталгаажсан зураг төслийн тоо-500	Захиал агчийн хөрөнгө өр	Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох норм, дүрмийн шаардлага хангуулан, магадлал төслийг холбогдох норм, дүрмийн шаардлагыг хангаж, магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр баталгаажуулсан байна. - БХТ ТӨААТҮГ-ын Магадлалын хэлтэс тайлангаа БХБЯ-д хагас бүтэн жилээр ирүүлж, тайлагнасан байна.	БХБЯ, БХТ ТӨААТҮГ	- Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулийн дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх шатанд "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" /БНБД 30-01-04/, "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 35-01-22/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД 31-112-11/ болон холбогдох бусад норм, стандартын шаардлагыг хангуулан хянаж баталгаажуулан ажиллаж байна. Энэ хүрээнд: - Улсын төсөв болон хувийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд хэрэгжих барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааны

										<p>тайланг 2024.12.10-ны өдрийн байдлаар хүлээн аваад байна.</p> <p>- 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 2422 ажлын гэрээ байгуулан барилга байгууламжийн ажлын зураг төсөл, төсөвт магадлал хийх ажлыг зохион байгуулж 2200 ажлыг дүгнэлтийн нэгтгэлээр баталгаажуулсан байна</p> <p>Үүнээс: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1685, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 515 төсөл арга хэмжээний ажлын зураг төсөл төсвийг баталгаажуулсан байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Орон сууцны барилга – 295 2. Сургууль - 72 3. Цэцэрлэг - 61 4. Эмнэлэг - 37 5. Дотуур байр - 12 6. Соёл, олон нийт - 38 7. Үйлдвэрийн барилга - 57 8. Усны барилга байгууламж – 81 9. Гадна инженерийн шугам сүлжээний - 213 10. Засварын ажил – 377 11. Тохижилт - 247 12. Ерөнхий төлөвлөгөө ТЭЗҮ - 25 13. Төсөв – 101 14. Газрын тосны барилга байгууламж – магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр-56 15. Худалдаа үйлчилгээ - 121 16. Оффис - 47 17. Бусад – 143 <p>Биелэлт 100%</p>
1.3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга									<p>- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад</p>

	<p>хэмжээг хэрэгжүүлэх, орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх (Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл) (ХБХЭХЗУАТ - 6)</p>				<p>- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн санал, үнэлгээний хуудсыг баталгаажуулах.</p>	<p>- Санал, үнэлгээний хуудсын тоо-450</p>	<p>-</p>	<p>Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн санал, үнэлгээний хуудсаар баталгаажуулсан байна.</p>	<p>БХБЯ, АНЗД</p>	<p>орлуулах дүрэм"-ийн 2.2-т заасны дагуу Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллаас хамааран барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс томилогдон үзлэг шалгалт хийн ажиллаж үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан актыг баталгаажуулан ажиллаж байна. "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтад заасны дагуу "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн"-д комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг гишүүнээр байнга оролцуулан ажиллуулж байна.</p> <p>- Улсын хэмжээнд 2008-2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 8437 барилга байгууламжийн улсын комиссын дүгнэлтийг /https://shilen.gov.mn/open-data/tag/цахим системд байршуулснаас 21 аймагт 4754, нийслэлд 3683 барилга байгууламжийн улсын комиссын дүгнэлт тус тус ил тод нээлттэй байршсан байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд нийт 573 барилга байгууламж, үүнээс 21 аймагт нийт 428 барилга байгууламж, үүнээс орон сууцны барилга 71, нийслэлд нийт 145 барилга байгууламж, үүнээс орон сууцны барилга 86 тус тус ашиглалтад орсон байна.</p>
--	--	--	--	--	--	--	----------	--	-------------------	---

										Биелэлт 100%	
1.4	Хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн барилга байгууламжийг үе шаттайгаар саадгүй, хүртээмжтэй болгох (НҮБ-ын ХБХЭ-ийн хорооноос Монгол Улсад ирүүлсэн зөвлөмж)					- Аймаг, нийслэлийн засаг дарга нарт “Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудын саадгүй байдал, хүртээмжийн байдлыг үнэлэх хуудас”-ны дагуу үнэлгээ хийх тухай зөвлөмж хүргүүлнэ.	- Зөвлөмжийн тоо-22	Нийслэл, орон нутгийн хөрөнгө оруулалт	- Шаардлагатай санхүүжилт шийдэгдэж хүртээмж нэмэгдсэн байна.	БХБЯ, ХНХЯ, АНЗД	- Аймаг, нийслэлийн засаг дарга нарт “Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудын саадгүй байдал, хүртээмжийн байдлыг үнэлэх хуудас”-ны дагуу үнэлгээ хийх ажлыг III, IV улиралд төлөвлөн зохион байгуулж, тайлан мэдээг холбогдох газарт нь хүргүүлж ажилласан байна.
1.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах чиглэлд холбогдох арга хэмжээг авах ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамруулах. (Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2)					- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамрагдсан байна.	Сургалтанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо-25	-	Хөдөлмөр эрхлэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтанд хамруулсан байна.	БХБЯ, МХШҮГ, ХНХЯ, ГЗБГЗЗГ, БХТ	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь заалтын хэрэгжилт болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний “4.1-д заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах чиглэлд холбогдох арга хэмжээг авах ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамруулах” ажлын хүрээнд тус яам болон харьяа байгууллагын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажиллуулж буй талаарх судалгааг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, ХНХЯ-нд 2023.12.19-ний өдрийн 3/4601 тоот

									<p>албан бичгээр хүргүүлж ажилласан.</p> <p>Уг судалгаагаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон харьяа агентлаг, байгууллагуудад 2023 оны жилийн эцсийн байдлаар 25 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны батлагдсан бүтэц, орон тооны 99 албан хаагчаас 2 албан хаагч хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажиллуулж буй талаарх судалгааг 2024 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж, ХНХЯ-нд 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 03/1917 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг судалгаагаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон харьяа агентлаг, байгууллагуудад 2024 оны эхний хагас жилийн байдлаар 7 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. Улсын Их Хурлаас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталснаар Засгийн газрын тухай хууль болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт орж газрын харилцаа, геодези,</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--

									зураг зүйн чиг үүргийг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэн учраас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон 21 аймгийн ГХБХБГазар, Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд ажиллаж буй албан хаагчдыг дээрх судалгаанд хамруулаагүй болно. Биелэлт 100%	
1.6	Барилгын үйл ажиллагаанд ХБИ-ийн төлөөллийг оролцуулж байх. (Барилгын тухай хуулийн 4.1.20 дах заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл)				- Комисст ажиллах ХБИ-д сургалт явуулж, гарын авлага гарган, норм ба дүрэм, үнэлгээ, түүний тайлангийн талаар мэдлэг ойлголтыг өгнө.	Тухай бүр	-	- Сургалтад хамрагдсан, барилгын үйл ажиллагаанд оролцох чадамжтай хөгжлийн бэрхшээлтэй хүний нөөцийг бүрдүүлсэн байна. - Комисст ажилласан болон барилгын үйл ажиллагаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	БХБЯ, БХТ ТӨААТҮГ, АНЗД, ТББ-ууд	- 2024 оны жилийн эцсийн байдлаар Барилга, хот байгуулалтын сайдын 2024.01.12 №11, 2024.01.26 №19, 2024.05.17 №90, 2024.05.17 №91, 2024.05.20 №92, 2024.06.03 №104, 105, 2024.07.09, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.09.25 №57, 2024.09.30 №58, 2024.10.21 №73, 2024.11.01 №84, №85, №88, 2024.11.13 №98 тус тус нийт 15 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажилласан. - Дээрх барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хүрээнд тус комиссын бүрэлдэхүүнд ажиллах төлөөллийг ХБХХЕГ-аас албан бичгээр авч хамтран ажилласан. Биелэлт 100%
1.7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурч боловсроход шаардлагатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.				Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурч боловсрох нөхцөл шаардлагыг	Дүрэм-1	ББННС	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурч боловсрох нөхцөл шаардлагыг тодорхойлох "Сургуулийн барилгын сургалтын	БХБЯ, БХТ	- "Сургуулийн барилгын сургалтын аюулгүй орчинд тавигдах техникийн шаардлага" баримт бичгийг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулж батлуулсан. 2024 оны ББННС-ийн төлөвлөгөө 2024.06.05-ны өдөр батлагдсан

	(Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 15.1.2)				тодорхойлох "Сургуулийн барилгын сургалтын орчинд тавигдах шаардлага" техникийн дүрэм боловсруулна .		орчинд тавигдах шаардлага" техникийн дүрэмтэй болсон байна.		бөгөөд ТӨБЗГ-тай ННББ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зөвшилцөж чадаагүй тул тендер зарлаагүй. Мөн 2024.11.13-ны өдрийн ННС-ийн удирдах зөвлөлийн хурлаар сангийн тодотголыг хэлэлцэж баталсан бөгөөд тус ажлыг 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусган батлуулсан. - Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийн дагуу техникийн даалгаварт тусгагдсан байгууллагуудаас дахин санал авахаар БХТ-ийн 2024.01.12-ны өдрийн 2/72 дугаартай бичгээр нормын төслийг илгээж, холбогдох саналыг авч тусгасан. - “Хүүхэд, залуучуудын боловсрол, сургалт, амралтын байгууллагын төлөвлөлтийн эрүүл ахуйн шаардлага” барилгын дүрмийг ШУТТЗ-ийн хурлаар 2024.08.25-ны өдөр хэлэлцүүлж дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Зөвлөлийн гишүүдээс өгсөн санал зөвлөмжийг тусган, төслийн боловсруулалтыг сайжруулан дахин ШУТТЗХ-аар хэлэлцүүлэхээр 2024.11.01-ний өдрийн 1/3070 дугаар албан бичгээр ирүүлээд байна. - Төслийг хянаж, бүрдлийн хангуулан, хурлын тов хүлээж байна. Биелэлт 100%	
1.8	Барилга, инженерийн чиглэлийн хүмүүст хөгжлийн				Ирүүлсэн зөвлөмжид эрхлэх асуудлын	Зөвлөмж-1	-	Ирүүлсэн зөвлөмжид эрхлэх асуудлын хүрээнд хамаарах	БХБЯ,	Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн 2024 оны 02 дугаар

	<p>бэрхшээлтэй ойлголт өгөх. (НҮБ-ын ХБХЭ-ийн хорооноос Монгол Улсад ирүүлсэн зөвлөмж)</p>				<p>хүрээнд хамаарах ажлыг хийж гүйцэтгэнэ.</p>			<p>ажлыг хийж гүйцэтгэсэн байна.</p>		<p>сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу өдрийн А/37 дугаар тушаалаар “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө болон салбарын ажилтны мэргэшлийн зэрэг горилох, сунгах шалгалтын хуваарыг тус тус баталсан. Тус сургалтын нэгдсэн хөтөлбөрт “Барилгын салбарын хууль, эрх зүйн шинээр батлагдсан хорм нормативын баримт бичиг” 40 цагийн лекц хичээлийн хүрээнд тус сургалтад хамрагдсан нийт салбарын инженер, техникийн ажилчдад хөгжлийн бэрхшээлтэй, саадгүй, хүртээмжийн талаар мэдлэг, ойлголт өгөх, Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх /БНБД 35-01-22/ барлын норм дүрмийн талаар сургалт хийж аливаа зураг төсөл төлөвлөхдөө мөрдөх юм.</p> <ul style="list-style-type: none"> - Мөн дээрх сургалтын хөтөлбөрийн дагуу холбогдох сургалтуудын зохион байгуулж нийт 957 салбарын инженер, техникийн ажилчид хамрагдсан байна. Үүнээс: <p>Сугасан нь 427:</p> <ul style="list-style-type: none"> - Зөвлөх архитектор -4; - Зөвлөх инженер -42; - Тэргүүлэх төсөвчин 11; - Мэргэшсэн архитектор -48; - Мэргэшсэн инженер – 268; - Мэргэшсэн төсөвчин -34 <p>Шинээр авсан нь 530:</p>
--	--	--	--	--	--	--	--	--------------------------------------	--	---

										<ul style="list-style-type: none"> - Зөвлөх архитектор -7; - Зөвлөх инженер -40; - Тэргүүлэх төсөвчин 8; - Мэргэшсэн архитектор -73; - Мэргэшсэн инженер – 367; - Мэргэшсэн төсөвчин -35 <p>Биелэлт 100%</p>
Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах хүрээнд										
2.1	Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн хамрагдах хувь хэмжээг нэмэгдүүлэх (“Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-3.1.1, 4.1.1)				Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцад хамруулах журам”-ын шаардлагыг хангуулна.	Түрээсийн орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн хамрагдах хэмжээ-10%	-	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцад хамруулах журам”-ын шаардлагыг хангуулж түрээсийн орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн хамрагдах хэмжээг 10 хүртэл хувиар нэмэгдүүлсэн байна.	БХБЯ, ХНХЯ	УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “АЛСЫН ХАРАА-2050” УИХ-аар баталсантай холбоотойгоор ЗГ-ын 2015 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан Түрээсийн орон сууц хөтөлбөр хүчингүй болсон. Үүнтэй холбоотойгоор “Зорилтод бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах жухам”-ыг баталсан БХБ-ын сайдын 2017 оны 26 дугаар тушаалын эрх зүйн үндэслэл байхгүй болсонтой холбоотойгоор эрх зүйн орчныг тодорхойлох хууль тогтоомжийн эрэлт хэрэгцээний тандан судалгаагаар Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн баригдсан.
Биелэлт 100%										

2.2	Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг зээлийн шаардлага хангасан хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхөд дараалал харгалзахгүй олгох, Зээлийн батлан даалтын сангаар баталгаа гаргах асуудлыг байршил харгалзахгүй шийдвэрлэх ("Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр"- 3.1.3, 4.3.1)				Орон сууцны ипотекийн зээлд хамрагдах хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн зээлийн хүсэлтийг дараалал харгалзахгүйг ээр зээлийн хорооны хурлаар хэлэлцүүлэх, шийдвэрлэгдсэн нөхцөлд зээлийн санхүүжилтээс тэргүүн ээлжид олгохыг эрэлхийлэх;	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнийг халамжил даг гэр бүлд зээлд хамрагдсан иргэдийн тоо	-	Хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ипотекийн зээлд хамруулах чиглэлд дэмжлэг үзүүлсэн байна.	БХБЯ, ТББ-ууд	УИХ-д өргөн барьсан Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийн 4.3-т "Зорилтот бүлгийн иргэн" гэж хүн амын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон Монгол Улсын иргэнийг тодорхойлон тусгасан бөгөөд 7.7-д Зорилтот бүлгийн иргэн, өрхийн түрээсийн төлбөрийн зөрүүг иргэн, өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан хүн амын хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн тухайн жилийн төсвийн төсөлд бүрэн болон хэсэгчилэн тусгаж болно гэж заасан. Хууль батлагдаж хэрэгжиж эхэлснээр дээрх заалтуудын хүрээнд ХБИ буюу зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууц болон ипотекийн зээлд байршил харгалзахгүй хамрагдах боломж бүрдэх юм. Биелэлт 100%
Гурав. Дэд салбар зөвлөлийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд										
3.1	Дэд зөвлөлийн ээлжит хуралдааныг зохион байгуулах, үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг боловсруулан батлуулах, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.				Дэд зөвлөлийн хурал, төлөвлөгөө, тайлагнах тоо	- Төлөвлөгөө - 1 - Тайлан – 1	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллан, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудад хугацаанд хүргүүлсэн байна.	БХБЯ, ХНХЯ, ГЗБГЗЗГ, БХТ, ТББ-ууд	- ЗГХЭГ-аас үүрэг чиглэл өгсөний дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажлын алба бүх Дэд зөвлөлүүд дээр 2023.12.07-08-ны өдрүүдэд уулзалтын хуваарийг дагуу ирж уулзалт хийсэн. Энэхүү уулзалтын бэлтгэлийг хангаж манай дэд зөвлөл уулзалтын удирдамжын дагуу дэд зөвлөлийн үйл ажиллагаа, хийж хэрэгжүүлсэн ажил, 2023 оны биелэлт, 2024 оны төлөвлөгөөний санал, цаашид авах

										<p>арга зэргийг танилцуулж, улмаар ХБХЭХОТБДД-ийн 2023 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2024 оны ажлын төлөвлөгөөний төсөл болон бусад холбогдох мэдээллийг 2023.12.12-ны өдөр Soogii92@yahoo.com , цахим хаягаар хүргүүлсэн.</p> <p>-Мөн 2023.12.27-ны өдөр цахимаар хурал зохион байгуулан 2024 оны ажлын төлөвлөгөөг байршуулан зөвлөлийн гишүүдээс санал авч тусгасан ба 2024 оны ажлын төлөвлөгөөний төслийг ХБХХЕГ-аас нэхсэн хугацаанд заасан цахим хаягаар ирүүл гэсний дагуу Soogii92@yahoo.com цахим хаягаар болон 2024.01.03-ны өдөр "Saikhanaa" вайбер чатаар тус тус илгээж хүргүүлсэн.</p> <p>- Дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөг эцэслэн 2024 оны 01 дүгээр сарны 20-ны өдөр тус зөвлөлийн даргаар батлуулан, 2023 оны биелэлтийн хамт 2024.01.23-ны өдрийн 3/222 дугаар албан бичгээр болон tuyasaikhan111@gmail.com, boloroo.amjilt@gmail.com цахим хаягаар ХНХЯ болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.</p> <p>- Дэд зөвлөлийн хурлыг 2024.02.20-ны өдөр танхимаар тус зохион байгуулан 2023 оны хэрэгжилт, батлагдсан 2024 оны ажлын төлөвлөгөөг дахин хэлэлцэж санал зөвлөмж өгч тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

										<p>- Дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар 2024.06.13-ны өдөр songoo2008@yahoo.com tuyasaikhan1111@gmail.com, цахим хаягаар хүргүүлсэн.</p> <p>- Дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг гарган, холбогдох мэдээллийн хамт 2024.12.08-ны өдөр duuya@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн. Мөн 2025 оны 01 дүгээр сарын 7,8-ны өдрүүдэд Үндэсний зөвлөлийн ажлын албанаас дэд зөвлөлүүдийн тайланг болон 2025 оны ажлын төлөвлөгөөний төсөлтэй танилцах сонголт зохион байгуулах ба тус дэд зөвлөлөөс бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Биелэлт 100%</p>
3.2	Салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах				Барилгын салбарын норм, нормативын баримт бичгийг сурталчлах, сургалт зохион байгуулах, олон нийтэд мэдээллэх	- Сургалтын багц - 1	-	Сургалтад яам, харьяа байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийг хамруулсан байна.	БХБЯ, ХНХЯ, ГЗБГЗЗГ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд, ААН-үүд	<p>- Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу өдрийн А/37 дугаар тушаалаар “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө болон салбарын ажилтны мэргэшлийн зэрэг гориллох, сунгах шалгалтын хуваарыг тус тус баталсан.</p> <p>Тус сургалтын нэгдсэн хөтөлбөрт “Барилгын салбарын хууль, эрх зүйн шинээр батлагдсан хорм нормативын баримт бичиг” 40 цагийн лекц хичээлийн хүрээнд тус</p>

									<p>сургалтад хамрагдсан нийт салбарын инженер, техникийн ажилчдад хөгжлийн бэрхшээлтэй, саадгүй, хүртээмжийн талаар мэдлэг, ойлголт өгөх, Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх /БНБД 35-01-22/ барлгын норм дүрмийн талаар сургалт хийж аливаа зураг төсөл төлөвлөхдөө мөрдөх юм.</p> <p>- Мөн дээрх сургалтын хөтөлбөрийн дагуу холбогдох сургалтуудын зохион байгуулж нийт 957 салбарын инженер, техникийн ажилчид хамрагдсан байна. Үүнээс:</p> <p>Сугасан нь 427:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Зөвлөх архитектор -4; ✓ Зөвлөх инженер -42; ✓ Тэргүүлэх төсөвчин 11; ✓ Мэргэшсэн архитектор -48; ✓ Мэргэшсэн инженер – 268; ✓ Мэргэшсэн төсөвчин -34 <p>Шинээр авсан нь 530:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Зөвлөх архитектор -7; ✓ Зөвлөх инженер -40; ✓ Тэргүүлэх төсөвчин 8; ✓ Мэргэшсэн архитектор -73; ✓ Мэргэшсэн инженер – 367; ✓ Мэргэшсэн төсөвчин -35 <p>- Салбарын инженер техникийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох болон бусад богино хугацааны сургалтын хөтөлбөрт Хөгжлийн бэрхшээл, нийтийн хүртээмж, нийгмийн хандлага, харилцаа, хөгжлийн талаар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, ажил олгогч нар</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--

										<p>ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдалд нийцүүлэх, холбогдох норм ба дүрэм, хууль, тогтоомж, холбогдох бодлого, эрх зүйн орчны талаарх мэдлэг мэдээлэл олгох чиглэлийн сургалтуудыг тусгасан дараах сургалтуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Барилгын салбарын норм, нормативыг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд БХТ норм нормативын баримт бичгийг танилцуулах сурталчлах, сургалтын аяныг 2024 оны 03-04 дүгээр саруудад “Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-тай хамтран зохион байгуулсан. Тус аяны хүрээнд сургалтыг цахим болон танхимаар үнэ төлбөргүй зохион байгуулсан бөгөөд салбарын инженер техникийн ажилтан албан хаагчдад 5 кредит цаг олгож, гэрчилгээ олгосон. Сургалтад давхардсан тоогоор 456 салбарын инженер, албан хаагчид хамрагдаж, 1 багц цаг хангасан-35, 2 багц цаг хангасан-29, 3 багц цаг хангасан -16, 4 багц цаг хангасан -18, 5 багц цаг хангасан-37 мэргэжилтэн, албан хаагч, нийт 135 инженер техникийн ажилтанд гэрчилгээ олгосон байна. - Мөн аяны хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн 2024” -ийг “Аюулгүй барилга, аюулгүй орчин, аюулгүй ажиллагаа” уриан дор
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										<p>Орхон аймгийн Эрдэнэт хотод зохион байгуулсан. Зөвлөгөөнд 21 аймаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 400 гаруй төлөөлөл оролцсон.</p> <p>2024 оны 04 дүгээр сард “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” сэдвийн хүрээнд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Барилгын салбарын норм, нормативыг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд ХББОСЯ, БХТ нь Хууль эрх зүй, норм нормативын баримт бичгийг танилцуулах сурталчлах ажлын хүрээнд: <ol style="list-style-type: none"> 1. Барилгын салбарын эрх зүйн актын эмхэтгэл 2024; 2. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалтын -1ш; 3. Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалтын- 1ш; - Батлагдаж гарсан барилгын норм дүрмийг постер байдлаар бэлтгэн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан баримт бичгүүдийг сурталчлан ажилласан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - БХТ ТӨААТҮГ-ын олон нийтийн сүлжээнд байршуулсан нийт 57-н постер мэдээлэл, танилцуулгын сурталчилгааг 1,899 удаа сэтгэгдэл үлдээн санал өгч, 3,213 удаа share хийж түгээсэн байна. БХТ ТӨААТҮГ-ын https://mcis.gov.mn/
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									<p>вебсайтад байршуулсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Техникийн зохицуулалт-4, - Барилгын норм ба дүрэм – 195, - Стандарт – 637, - Барилгын дүрэм, заавар, цомог, аргачлал, бусад - 230 баримт бичгийг олон нийтэд түгээн сурталчилж, эх хувиар үзэх боломжийг бүрдүүлсэн. - Салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж https://mcis.gov.mn / веб сайтад байршуулсан баримт бичиг тус бүрт түүвэрлэн орж үзэхэд эрэлт хэрэгцээ шаардлагаасаа хамаарч үзэлтийн тоо янз бүр бөгөөд хамгийн багадаа 50-80, хамгийн их нь 537-1850 удаагийн хандалт хийгдсэн байна. <p>Биелэлт 100%.</p>
3.3	Зөвлөлийн үйл ажиллагааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой салбарт тулгамдаж буй асуудлын талаар “Асуудал-шийдэл” хэлэлцүүлгийг зохион байгуулах. (ХБХЭХЗҮАТ - 21)			ХНХЯ болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл, холбогдох байгууллагуу дтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулах.	- Хэлэлцүүлэг-1, - Зөвлөмж – 1	-	Холбогдох байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг, зохион байгуулж, зөвлөмж гаргах.	БХБЯ, ХНХЯ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд	- 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн 2024” -ийг “Аюулгүй барилга, аюулгүй орчин, аюулгүй ажиллагаа” уриан дор Орхон аймгийн Эрдэнэт хотод зохион байгуулсан. Зөвлөгөөнд 21 аймаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 400 гаруй төлөөлөл оролцсон. 2024 оны 04 дүгээр сард “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” сэдвийн хүрээнд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан.

										<p>- Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардага түүнд өөрчлөлт оруулах тухай асуудлаар “Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл өөрчлөлт, шинэчлэлт-2024” хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөгийг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Монголын барилгын үндэсний ассоциаци /түншлэл/ ТББ-тай хамтран зохион байгуулж, 118 аж ахуй нэгжийн төлөөлөл оролцож, санал хүсэлтээ илэрхийлсэн.</p> <p>Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардага түүнд өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллах хүсэлт гаргасан 16 байгууллагын 22 төлөөлөлийг бүртгэж, ажлын хэсгийг ХББОС-ын сайдын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 126 дугаар тушаалаар байгуулсан.</p> <p>- Тус уулзалт, хэлэлцүүлгээр барилгын үйл ажиллагаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог нэмэгдүүлэх, энэ талаар 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах ажлын санал, тухайн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр тулгамдсан асуудал, шийдлийн талаар санал солилцсон.</p> <p>Биелэлт 70%.</p>
3.4	“Хөгжлийн бэрхшээлтэй хүнд				Хөдөлмөр, нийгмийн	Шилдэг ААНБ-ын	-	“Хөгжлийн бэрхшээлтэй хүнд	БХБЯ, ХНХЯ,	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус

	<p>хүртээмжтэй бүтээн байгуулалтын төрөлд оны шилдэг"-ийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх. <i>("Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах журам"-ын 2.1.7)</i> (ХБХЭХЗҮАТ - 24)</p>				<p>хамгааллын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах журам"-ын хэрэгжилтийг хангуулсан байна.</p>	санал – 3 хүртэл		<p>хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулсан байна.</p>	БХТ ТӨААТҮГ	<p>зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах журам"-ын дагуу нэр дэвшүүлж буй барилга байгууламжийн мэдээллийг дэд болон салбар зөвлөлүүд ХБХХЕГ-т албан бичгээр болон цахимаар хүрүүлсэн. Тус газраас холбогдох журмын дагуу ирүүлсэн төслүүдийг үнэлж 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, оны шилдэгийг шалгаруулсан. Биелэлт 50%.</p>
--	---	--	--	--	---	------------------	--	---	-------------	---

ТАНИЛЦСАН:
ББМҮБХЗГ–ЫН ДАРГА

Д.ГАНТУЛГА

НЭГТГЭСЭН:
ББМҮБХЗГ–ЫН ШИНЖЭЭЧ

Б.ГАНДОЛГОР